



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2007 оны 5 сарын 17 өдөр

Дугаар 230

Улаанбаатар хот

**Авто замын газрын дүрэм
батлах тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, "Авто замын тухай" хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг "Нийслэлийн Авто замын газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Байгууллагын дүрэм болон Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг боловсруулж батлан мөрдөн ажиллахыг Авто замын газар /Д.Бат-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ц.Болдсайхан/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2005 оны 89 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР



Нийслэлийн Засаг даргын 2007 оны
5 дугаар сарын 17-ны өдрийн
236 дугаар захирамжийн
хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АВТО ЗАМЫН ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Авто замын газар /цаашид "Авто замын газар" гэнэ / нь Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, авто замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөлтийг боловсруулан, авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлан хамгаалах, ашиглалтад хяналт тавих, нийслэлийн авто замын санг бүрдүүлэх, гэнэтийн болон байгалийн гамшгийн улмаас авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл саатлыг засварлан сэргээх ажлыг зохион байгуулах, авто замын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, технологийн хяналтыг хэрэгжүүлэх, зам талбай байгуулах зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, нарийвчилсан судалгаа хийх, авто замын ачааллын судалгаа хийх, авто зам замын байгууламжийн бүртгэл мэдээлийн санг хөтлөн ажиллуулах, авто зам, замын байгууламжийн хийц бүтээцэд туршилт, шинжилгээний ажлыг хийх, орцын нормыг тогтоох, барилгын объект дээр нь лабораторийн хэмжилт шалгалт, хяналт хийх, дүгнэлт гаргах үүрэг бүхий өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах "Хэрэгжүүлэгч агентлаг" мөн.

1.2. Нийслэлийн Авто замын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Авто замын тухай хууль, Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, захирамж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Нийслэлийн Авто замын газар нь Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Улаанбаатар хотын ерөнхий менежерт ажлаа тайлагнана.

1.4. Нийслэлийн Авто замын газар нь аж ахуйн тооцооны үндсэн дээр улсын үйлдвэрийн газрын эрхтэйгээр бие даан үйл ажиллагаа явуулж, авто замын хяналтанд зарцуулсан хөрөнгө, авто зам ашигласаны төлбөр, зураг төсөл судалгааны болон бусад ажил үйлчилгээний орлогоос бүрдэнэ.

1.5. Нийслэлийн Авто замын газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээд мөн.

1.6. Нийслэлийн Авто замын газар нь тогтоогдсон журмын дагуу хийгдсэн тамга тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас болон банкны харилцах данстай байна.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч тогтоож, даргыг томилж, чөлөөлнө.

2.2. Газрын орлогч даргыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санал авсны үндсэн дээр Газрын дарга томилж, чөлөөлнө.

2.3. Нийслэлийн Авто замын газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн удирдлаган дор үйл ажиллагаагаа явуулж ажлын тайланг тавьж ажиллана.

2.4. Газрын дарга нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоож мөрдүүлэх ба ажилтнуудыг томилж, чөлөөлнө.

2.5. Газрын дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод ашиглаж, эзэмшинэ.

2.6. Газрын дарга /түүний эзгүйд орлогч дарга/ газрыг төлөөлөн бусад байгууллагатай харилцаж, өөрийн бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

2.7. Газрын зорилт, чиг үүрэгтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж, зөвлөх үүрэг бүхий даргын дэргэдэх Зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн гишүүд гагцхүү зөвлөх эрхтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга тушаал гаргаж батлана.

2.8. Газрын дарга нь Төсвийн байгууллагын, удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу үр дүнгийн гэрээнд тусгасан бүтээгдхүүнийг Нийслэлийн Засаг даргад нийлүүлнэ.

Гурав. Газрын үүрэг

3.1. Газар нь Монгол улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, тухайн жилийн нийгэм эдийн засгийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

3.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, тухайн оны нийслэлийн нийгэм, эдийн засгийн зорилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр үнэн бодитой гаргана.

3.3. Нийслэлийн авто замын сангийн хөрөнгийг бүрдүүлж Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, авто замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөлтийг боловсруулан, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлан хамгаалах, ашиглалтад хяналт тавих, зам талбай байгуулах зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, нарийвчилсан судалгаа хийх, авто зам замын байгууламжийн бүртгэл мэдээлийн санг хөтлөн тэргүүний техник технологи нэвтрүүлэх, программ хангамжийг сайжруулан гэнэтийн болон байгалийн гамшгийн улмаас авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл саатлыг засварлан сэргээх ажлыг удирдан зохион байгуулах /батлагдсан санхүүжилтийн хүрээнд/, авто замын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, чанарын болон технологийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.

3.4. Нийслэлийн нутаг дэвсгэр дээр авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлан хамгаалах, хайгуул зураг төслийн ажил эрхлэх аж ахуйн байгууллагад тусгай зөвшөөрөл олгоход болон цуцлахад санал өгч, авто замын салбарт зах зээлийн харилцааг төлөвшүүлэх, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүдийн шударга өрсөлдөх нөхцлийг бүрдүүлнэ.

3.5. Нийслэлд баригдсан авто зам, замын байгууламжийг ашиглалтанд хүлээн авч, паспортжуулан мэдээллийн санг байгуулж, шаардлагатай мэдээллийг шинэчлэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт болон холбогдох байгууллагуудад тухай бүр гарган өгч ажиллана.

3.6. Авто зам, замын байгууламжид техник ашиглалтын түвшин тогтоох болон зам тээврийн ослын судалгаа, замын хөдөлгөөний эрчмийн тооллогын мэдээлэл тогтмол авч, замын мэдээллийн санд оруулан авто замын сүлжээний менежмент, ойрын болон хэтийн төлөвлөлт, засвар, арчлалтын болон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангах ажилд ашиглана.

3.7. Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлан хамгаалах, ашиглалтад хяналт тавих, авто замын материаллаг баазыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулж, барилга засвар, арчлалтын ажлыг чанартай гүйцэтгүүлэх, санхүүжүүлэх, байнгын ашиглалтад хүлээн авч, цаашид арчлан хамгаалагчийг тогтоох, эдгээр ажлын зардлын бүтцэд шинжилгээ хийх болон технологийн үйл ажиллагааг боловсронгуй болгох санал төсөл боловсруулна.

3.8. Авто замын сүлжээний төлөвлөлтийн болон авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлан хамгаалах, ашиглалтад хяналт тавих, зураг төсөл боловсруулахтай холбогдсон стандарт, норм, нормативыг хот төлөвлөлтийн болон байгаль орчин, авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангахуйцаар боловсруулах, зохих журмын дагуу батлуулахад оролцон, биелэлтийг хэрэгжүүлэн ажиллана.

3.9. Нийслэлийн захиалгаар авто зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөх, засварлах ажлын техникийн даалгаврыг батлуулан, түүний дагуу зураг төсөл боловсруулах буюу захиалан хийлгэнэ.

3.10. Газар нь хөрөнгө, санхүүгийн чадавхиа нэмэгдүүлэх, бизнесийн төлөвлөгөө гарган аж ахуйн тооцоон дээр ажиллан, захиалагчаар ажиллаж буй авто зам, замын байгууламжийн барилга угсралт, засварын ажлын техник

хяналтын зардал, авто замын мэдээллийн сангаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээллээр хангасны төлбөр, зураг төсөл зөвшөөрөлцөж техникийн шийдэл гаргасны төлбөр, авто замын материал шинжилгээний лабораторын орлого, үйлдвэрлэл, судалгаа шинжилгээний болон хуулинд заагдсан бусад ажил үйлчилгээний орлогоос үйл ажиллагааныхаа зардлыг нөхөх зарчмаар ажиллана.

3.11. Нийслэлд авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлан хамгаалах, хөдөлгөөн зохицуулах гэрэл дохио тэмдэг тэмдэглэгээний үйлдвэрлэл, авто замын ус зайлуулах байгууламж, материал үйлдвэрлэл, лабораторийн ажил эрхэлдэг төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, дараах хэлбэрээр харилцаж ажиллана.

а/ Төрийн өмчит компаний захирлыг ажилд томилох, чөлөөлөхөд мэргэжлийн байгууллагын хувьд санал өгнө.

б/ Компаниудын материаллаг баазыг бэхжүүлэх, техник технологи, инженер техникийн ажилтнаар бэхжүүлэх, хувьчлах асуудлыг төлөвлөн шийдвэрлэхэд оролцоно.

в/ Салбарын чиглэлээр гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, гадаад оронд туршлага судлах, суралцах ажлыг нэгтгэн зохион байгуулж энэ асуудлаар гадаадад ажиллах мэргэжилтнүүдийг томилох, ажлын гүйцэтгэлийг дүгнэж ажиллана.

г/ Нийслэлийн авто зам, замын байгууламж, хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэглэгээ, гэрэл дохионы барилга, засвар арчлалт, хамгаалалтын болон цаг үеийн асуудлаар сард шаардлагатай үед шуурхай зөвлөгөөн зохион байгуулж ажиллана.

3.12. Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх, салбарын бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг боловсронгуй болгох санал боловсруулна.

3.13. Нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, авто замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг үндэслэн хотын замын сүлжээг ойрын болон хэтийн хугацаанд хөгжүүлэх төлөвлөлтийг боловсруулах, авто зам, замын байгууламжийг барьж байгуулах зураг төсөл техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, тооцоо судалгаа, хайгуулын ажлын зураг төслийг төлөвлөгөөнд тусгуулан, урьдчилан боловсруулж ажиллана.

3.14. Хотын ерөнхий төлөвлөгөө, авто замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг үндэслэн тухайн нутаг дэвсгэр, хорооллын замын сүлжээний нарийвчилсан төлөвлөлт боловсруулан, батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.15. Нийслэлийн нутаг дэвсгэр дээрх авто зам, замын байгууламжид жил бүр дулааны улирал эхлэхээс өмнө тогтоосон журам, технологийн зааврын дагуу үзлэг, тооллого явуулж, засвар арчлалтын ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

3.16. Нийслэлийн замын санг бүрдүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх болон замын сангийн задаргааны талаар тооцоо судалгаа хийж холбогдох газруудад оруулан шийдвэрлүүлнэ.

3.17. Улаанбаатар хотын захиалгаар ажил гүйцэтгэх хүсэлт гаргасан авто зам, замын байгууламжийг барих, засварлах зураг төсөл зохиох, зөвлөхийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санхүү эдийн засаг, үйл ажиллагааны мэдээ тайланг нэгтгэн судалгаа дүгнэлт хийж үйл ажиллагааг нь мэргэжлийн төвшинд хүргэх механизм бүрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.18. Авто зам, замын байгууламжийн барилга, засвар арчлалтын үйлчилгээ, материаллаг бааз, боловсон хүчний хангалт, үйл ажиллагааны талаар шаардлагатай мэдээллийн сан бий болгох, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зам, тээврийн сүлжээтэй холбогдолтой мэдээ, мэдээлэл, шинэ технологи, хууль тогтоомж, норм норматив, стандарт, олон улсын гэрээ хэлэлцээр, конвенцийн талаархи мэдээллээр хангаж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

3.19. Байгууллагын инженер техникийн ажилтнуудыг өндөр мэргэжлийн дадлага туршлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх, мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, давтан сургах, хөдөлмөрлөх нөхцлийг сайжруулах арга хэмжээ авах болон нийслэлийн авто замын салбарын аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээг тодорхойлж, зам барилга, засвар арчлалтын ажил эрхлэгчдийг мэргэшүүлэх, мэргэжлийн зэргийг дээшлүүлэх семинар сургалт зохион байгуулах, мэргэжлийн зөвлөгөө тусламж үзүүлнэ.

3.20. Авто зам замын байгууламжийн зураг төслийг боловсруулах тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу авч шаардагдах инженер техникийн ажилтан, техник хэрэгсэл, программ хангамж, норм норматив стандартууд, хэмжилтийн багаж хэрэгслүүдийг бүрдүүлэн ажиллахад санхүүгийн дэмжлэг авах.

3.21. Авто зам, замын байгууламжийн зураг төслөөр дамжуулан зам барих тэргүүний техник технологийг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, өртөг зардлыг хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах.

3.22. Авто зам замын байгууламжийн зураг төсөл боловсруулах явцад бүх төрлийн инженерийн шугам сүлжээтэй уялдуулах, ашиглагч байгууллагуудаас техникийн нөхцөл авах, авто зам доогуурхи шугам сүлжээний өөрчлөлтийн зураг төслийг захиалан хийлгэх, зөвшөөрөлцөх, хяналт тавих.

3.23. Улсын болон нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан объектуудын зураг төслийн ажлуудыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх.

3.24. Нийслэлийн шалган бүртгэх товчоодын байршилыг оновчтойгоор тогтоож, үйл ажиллагааг нь эрхлэн гүйцэтгэнэ.

3.25. Нийслэлийн авто замын сүлжээг хөгжүүлэх талаар олон улсын байгууллага, гадаад орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээр, Монгол улсын нэгдэн орсон Олон улсын конвенцээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.26. Нийслэлийн авто замын сүлжээг хөгжүүлэх, тус газрын үйл ажиллагааг өргөтгөх, боловсон хүчнийг мэргэшүүлэх, авто зам, замын байгууламжийн техник технологи зураг төслийн талаар бусад орны туршлагыг судлах, хамтран ажиллах гадаад харилцааны чиг бодлогыг тогтоож, хэрэгжүүлнэ.

3.27. Нийслэлийн авто замын салбарын ажлын талаарх мэдээлэл, ололт амжилт, зөрчил дутагдал, өөрчлөлтийн тухай олон нийтэд мэдээлж, сурталчлах ажлыг зохион байгуулна.

3.28. Авто зам, замын байгууламжийн барилга, засвар арчлалтын ажлын зохион байгуулалт болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар арга зүйн туслалцаа үзүүлж, энэ талаарх хууль тогтоомж, заавар, журмын биелэлтэд хяналт тавина.

3.29. Авто замын тухай хуулийг хэрэгжүүлэх, хууль, дүрэм, журам зөрчиж авто зам, замын байгууламжийг эвдлэн сүйтгэж, зүй бус харьцаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын аливаа үйл ажиллагааны талаар холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээлэн, холбогдох хууль хяналтын байгууллагатай хамтран шаардлагатай тохиолдолд шүүхэд хандан шийдвэрлүүлэн ажиллаж, богино хугацаанд хохирлыг арилгуулан засч залруулах үйл ажиллагаа явуулна.

3.30. Авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын талаар нийслэлийн дүүргүүд, Мэргэжлийн хяналтын болон Замын цагдаагийн газар, бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

3.31. Тус газрын "Замын материал шинжилгээний лаборатори" нь Авто замын барилга, засвар арчлалт, замын байгууламжийн ажилд хэрэглэх бүх төрлийн материал, бэлэн бүтээгдэхүүнд туршилт шинжилгээ хийж дүгнэлт гаргаж ажиллана.

3.32. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд хүргүүлж хянуулна.

3.33. Төрийн албаны болон Хөдөлмөрийн тухай хууль, газрын дотоод журмын дагуу ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

Дөрөв. Газрын эрх

4.1. Газрын өмч хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрэмд нийцүүлэн эзэмшин, ашиглаж, захиран зарцуулна.

4.2. Авто замын салбарын холбогдолтой асуудлаар салбарын сайд болон Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжийн төслийг боловсруулан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт танилцуулан холбогдох газруудаас санал авсны үндсэн дээр хамтарсан тушаал, захирамж гаргуулж хэрэгжүүлнэ.

4.3. Авто замын ажил үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад бүртгэл, хяналт шалгалт хийж ажиллах, тэдэнд шаардлагатай мэдээ мэдээллээр хангах үйлчилгээг төлбөртэй явуулж болно.

4.4. Газар нь үйл ажиллагааг өргөтгөх, ашиг орлого олж өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зорилгоор гадаад, дотоодын холбогдох байгууллагатай харилцаж, Нийслэлийн Засаг даргын болон холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн дагуу гэрээ хэлцэл хийж, хамтран ажиллана.

4.5. Нийслэл хотын өнгө үзэмж, архитектурын ансамбльд сайнаар нөлөөлөхүйц, орчин үеийн техник технологийн болон дизайны шийдэл бүхий авто зам, замын байгууламж, гүүр, гүүрэн гарцуудыг барих зураг төсөл зохиох, гадаад дотоодын хөрөнгө оруулагчийг татах зорилгоор сонгон шалгаруулах уралдаан зарлах, дүгнэх сурталчлах, зөвлөлгөөн, хурал семинар зохион байгуулах.

4.6. Авто зам, замын байгууламжийн барилга, өргөтгөл, шинэчлэлт, засварын ажлын зургийн даалгаврыг боловсруулж, батлуулна.

4.7. Авто замын мэдээллийн санг боловсронгуй болгох, зам барилгын болон зураг төслийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх чиглэлээр байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр санаачилж хэрэгжүүлэх санал гаргах.

4.8. Нийслэлийн авто замын салбарын төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, шинээр бий болгох, татан буулгах, тэдгээрийн үйлдвэрийн баазыг өргөтгөн бэхжүүлэх технологийн тоног төхөөрөмж, машин техникийг шилжүүлэх, актлах зэрэг асуудлуудын талаар санал гаргаж ажиллана.

4.9. Нийслэлийн төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагуудад өмчийг хүлээлгэн өгч эзэмшүүлэх асуудлаар төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч холбогдох байгууллагад саналаа өгнө.

4.10. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулж зөвшөөрөгдсөний үндсэн дээр газар нь өөрийн харъяа нэгжийг байгуулан ажиллуулж болно.

4.11. Нийслэлийн өмчийн авто зам, замын байгууламжийг нэгдсэн данс бүртгэлдээ тусган авах, данснаас хасах, харьяаллыг нь өөрчлөн байгууллага хувь хүнд гэрээлэх, түрээслэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэн хэрэгжүүлнэ.

4.12. Авто зам, замын байгууламжийн барилга, засвар, арчлалтын ажлыг батлагдсан зураг төсөл технологийн горим зөрчиж, чанаргүй гүйцэтгэсэн, авто зам, замын байгууламжид гэмтэл учруулсан тохиолдолд буруутай этгээдийн зардлаар дахин хийлгэх ба зөрчил дутагдлыг арилгуулах, барилгын ажлыг зогсоох хүртэл арга хэмжээ авна.

4.13. Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр авто зам, замын байгууламж барих, засварлах, арчлан хамгаалах ажлыг захиалан хийлгэнэ.

4.14. Авто зам, замын байгууламжийг барих, өргөтгөн шинэчлэх, засварлах, арчлан хамгаалах ажлын болон зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна.

4.15. Гүйцэтгэгч байгууллага тухайн санхүүжилтыг зориулалтын бус зүйлд зарцуулснаас гарсан хохирлыг арилгуулахын тулд зохих мэргэжлийн хяналтын, санхүү, хуулийн байгууллагаар хянуулж шалгуулна.

4.17. Улаанбаатар хотын замын сүлжээ, замын хөдөлгөөний менежментийг сайжруулах чиглэлээр дотоод гадаадын зээл тусламжаар хэрэгжих төслүүдийн нарийвчилсан судалгааг хамтарч хийх, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, санал гаргах, зураг төсөл боловсруулахад оролцох.

4.18. Нийслэл хотын хот төлөвлөлт байгуулалт, барилгажилтын ажлыг замын сүлжээний хөгжилтэй нягт уялдуулах зорилгоор хот байгуулалтын мэргэжлийн комисст орж ажиллан улсын болон хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа шинээр баригдах болон өргөтгөл шинэчлэлт хийх, шилжүүлэн зөөх бүх төрлийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, авто болон төмөр зам, гүүр хоолой, тохижилт, зам талбайн зураг төсөлд санал өгч зөвшөөрөлцөж ажиллана.

4.19. Авто замын тухай хуулийн дагуу зам барилга, засварын ажилд хяналт тавихад шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж, хэмжилтийн багаж хэрэгсэл, машин техник худалдан авч хяналтын ажилд хэрэглэнэ.

4.20. Авто зам, замын байгууламжийн барилга, засвар, арчлалтын ажлыг гэрээгээр гүйцэтгэгч компаниудыг стандартын шаардлага хангаагүй, чанарын баталгаагүй материал ашиглахыг хориглож, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоон эрх бүхий байгууллагын дүгнэлтийг гаргуулна.

4.21. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь тусгай хамгаалалтгүй, эсхүл зөвшөөрөлгүйгээр гинжит болон тухайн авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын үзүүлэлтээс хэтэрсэн овор, даацтай тээврийн хэрэгслээр Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжаар зорчиход Монгол Улсын "Авто замын тухай" хуулийн дагуу шийдвэрлэнэ.

4.22. Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажил гүйцэтгэх үедээ иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь авто зам, замын байгууламжийг гэмтээх, сэтлэх шаардлагатай нөхцөлд тус газар нь зөвшөөрөл олгох, улмаар нөхөн сэргээх ажлын зардлыг тухайн ажлын төсөвт тусгуулан мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

4.23. Байгалийн болон гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөллөөр авто зам, замын байгууламжинд эвдрэл саатал гарч яаралтай засварлах шаардлага гарсан үед нийслэлийн аж ахуйн нэгж, байгууллага иргэдээс тээвэр, холбооны хэрэгсэл эд хөрөнгийг нөхөн олговортойгоор гаргуулах болон авто зам, замын байгууламжийг хэвийн байдалд оруулах ажлыг холбогдох байгуулагуудтай хамтран зохион байгуулна.

Тав. Эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, хяналт

5.1. Газар нь холбогдох хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгж байгууллагын татвар төлнө.

5.2. Газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

5.3. Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

5.4. Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

5.5. Газрын удирдлага нь газрын үйл ажиллагаанд хөндлөнгийн шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар хангана.

5.6. Газрын тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй бусад мөнгөн хөрөнгө, түүнчлэн орлого, зарлага, төлөгдөөгүй өр зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.

5.7. Үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах болон худалдах, хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг баримтална.

Зургаа. Байгуулах, бүртгэх, өөрчлөх, татан буулгах

6.1. Холбогдох хууль тогтоомжинд заагдсаны дагуу газрыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

Долоо. Хариуцлага

7.1. Газрын дарга, ажилтнууд нь байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Найм. Бусад

8.1. Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

8.2. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.